

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ НЭГТГЭСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbavars@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Н.Хулан
Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг:

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр	Товчилсон үгийн тайлбар Хүснэгт, график, зургийн жагсаалт Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3 3 4
Аудитын менежер: Т.Хонгорзул	Бүлэг 1. Төсвийн орлогын төлөвлөгөө 28,155.7 сая төгрөгөөр тасарсан байна.	5-8
Ахлах аудитор: Г.Шижирболд	Бүлэг 2. Төсвийн зарлагын гүйцэтгэл 89.5 хувьтай байна.	8-12
Аудитор: Н.Хулан	Бүлэг 3. Тайлант онд 95,975.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Бүлэг 4. Хөтөлбөрүүдэд 10,468.1 сая төгрөг зарцуулсан байна. Бүлэг 5. Нэмэлт төсвийг холбогдох журмын дагуу зарцуулсан байна.	12-13 13-17 17-18
	Дүгнэлт	19
	Зөвлөмж	20
	Тэргүүлэх аудиторовын тушаал	21

2022 оны 04 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70533539, 70533552
дугаарын утсаар харилцана
уу.

Тайланг ӨМТАГ-ын
www.umnuqovi@audit.gov.mn
цахим хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Нутгийн удирдлагын
ордон, 3 давхар, 303 тоот

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХХ	Хувь хүний
АТ	Авто тээвэр
ӨЯ	Өөрөө явагч
ОНХН	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн
ОАТ	Орлогын албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
БХ-ХО	Байгаль хамгаалах хөрөнгө оруулалт

Хүснэгт, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	5
Хүснэгт 2	Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл	6
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт	8
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	9
Хүснэгт 5	Төсвийн тэнцэл	10
Хүснэгт 6	Татварын өр төлбөр сумдаар	11
Хүснэгт 7	Худалдан авах ажиллагааны товчоо	12
Хүснэгт 8	Худалдан авах ажиллагааны товчоо	13
Хүснэгт 9	Төсөл арга хэмжээ	14
Хүснэгт 10	Дэд хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв	14
Хүснэгт 11	Нэмэлт төсвийн гүйцэтгэл	18
График 1	Худалдан авах ажиллагааны эх үүсвэрийн ангилал	13
График 2	Нэмэлт төсвийн зардлын ангилал	17

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт:

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхийг баталгаажуулж, дүгнэлт гарган Үндэсний аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэл
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Аудитын арга зүй:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/111 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Хамрах хүрээ:

Аудитад Өмнөговь аймгийн 2021 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэл, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Н.Хулан нар 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1 Төсвийн орлогын төлөвлөгөө 28,155.7 сая төгрөгөөр тасарсан байна

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн Хишиг" мөрийн хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн төлөвлөсөн байна.

1.3 Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4¹ заасны дагуу 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 01/645 дугаар албан бичгийн хамт аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлсэн.

1.4 Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах аргачлал"-ын дагуу Сангийн яамны "Э-тайлан" онлайн программаар нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргасан байна.

1.5 Сангийн яамнаас аймгийн нийт орлогын дүнг 154,694.0 сая төгрөгөөр хянасан бөгөөд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2020 оны 2/8 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын "2021 оны төсөв батлах тухай" тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 248,901.6 сая төгрөгөөр баталсан байна.

1.6 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2² -д заасан дагуу "2021 оны төсвийн тодотгол батлах тухай" 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын "Төсвийн тодотгол батлах тухай" тогтоолд төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,177.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 оны орлогын төлөвлөлт		
		Сангийн яам хянасан	Анх баталсан	Тодотгол хийсэн
А	1	2	3	4
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	178,355.8	154,694.0	248,901.6	257,079.1
НИЙТ ОРЛОГО	128,935.6	154,694.0	173,012.7	180,904.1
УРСГАЛ ОРЛОГО	128,504.0	154,634.0	172,952.7	180,461.5
Татварын орлого	111,726.8	124,787.0	129,787.0	138,846.2
Орлогын албан татвар	48,681.7	54,560.0	54,560.0	63,810.4
ХХ-ны орлогын албан татвар	49,526.5	55,860.0	55,860.0	64,810.4

¹ "аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж....."

² "тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах....."

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ХХ-ны орлогын албан татварын буцаан олголт	(844.8)	(1,300.0)	(1,300.0)	(1,000.0)
Өмчийн татвар	27,866.8	28,297.0	33,297.0	28,296.4
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	6,670.8	5,000.0	5,000.0	7,000.0
Тусгай зориулалтын орлого				
АТ болон ӨЯ хэрэгслийн албан татвар	6,670.8	5,000.0	5,000.0	7,000.0
Бусад татвар /төлбөр хураамж/	28,507.5	36,930.0	36,930.0	39,739.4
Татварын бус орлого	16,777.2	29,847.0	43,165.7	41,615.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	431.7	60.0	60.0	442.6
Хөрөнгө борлуулсны орлого	431.7	60.0	60.0	442.6
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,420.2	-	52,905.6	53,804.5
ОНХ-ын нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	13,941.3		16,732.1	17,014.6
УТ-с ОН-ын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-			
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35,277.3		35,734.2	36,350.6
ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого				
Бусад тусламж	201.6		439.3	439.3
Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих			22,983.3	22,370.44

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.7 Сангийн яамны хянасан орон нутгийн төсвийн суурь орлогын дүнг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9³-д заасны дагуу аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хэмжээнд төсвийг нэмэгдүүлэн 257,079.1 сая төгрөгөөр баталсан байна.

1.8 Өмнөговь аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн урсгал орлогын 76.9 хувь нь татварын орлогоос, 23.1 хувь нь татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.9 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2021 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 257,079.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс 228,923.4 сая төгрөг буюу 89 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	1	2	3	4=3-2	5
НИЙТ ОРЛОГО	178,355.8	257,079.1	228,923.4	(28,155.7)	89.0
УРСГАЛ ОРЛОГО	128,935.6	203,274.5	176,487.9	(26,786.6)	86.8
Татварын орлого	111,726.8	138,846.2	137,595.7	(1,250.5)	99.1
Орлогын албан татвар	48,681.7	63,810.4	68,370.5	4,560.1	107.1
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	45,184.2	61,990.9	65,310.6	3,319.7	105.4
Үйл ажиллагааны орлого	2,417.7	714.5	1,867.1	1,152.6	261.3
Бусад орлого		1,787.1	1,748.3	(38.8)	97.8
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний ОАТ	1,924.6	317.9	392.3	74.4	123.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(844.8)	(1,000.0)	(947.7)	52.3	94.8
Өмчийн татвар	27,866.8	28,296.4	30,585.7	2,289.3	108.1

³ “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах”

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үл хөдлөх хөрөнгийн татвар	27,830.6	28,260.0	30,545.2	2,285.2	108.1
Бууны албан татвар	36.3	36.4	40.5	4.1	111.3
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	6,670.8	7,000.0	8,683.2	1,683.2	124.0
АТ болон ӨЯ хэрэгслийн албан татвар	6,670.8	7,000.0	8,683.2	1,683.2	124.0
Бусад татвар /төлбөр хураамж/	28,507.5	39,739.4	29,956.3	(9,783.1)	75.4
Улсын тэмдэгтийн хураамж	418.1	670.3	439.6	(230.7)	65.6
Газрын төлбөр	7,743.6	15,017.6	7,877.0	(7,140.6)	52.5
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	2,082.3	2,350.0	3,827.1	1,477.1	162.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		-	11.4	11.4	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		149.5	360.2	210.7	241.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	16,315.0	19,030.4	13,934.6	(5,095.8)	73.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,239.5	1,916.5	2,572.3	655.7	134.2
Бусад татвар хураамж	236.0	202.7	288.2	85.5	142.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	473.1	402.4	646.1	243.7	160.6
Татварын бус орлого	16,777.2	63,985.8	38,412.4	(25,573.4)	60.0
Хувьцааны ногдол ашиг	10,502.4	26,500.0	25,691.8	(808.2)	97.0
Түрээсийн орлого	39.3	24.0	88.0	64.0	366.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,060.2	9,338.01	2,524.5	(6,813.5)	27.0
Урьд оны шилжих үлдэгдэл		22,370.44	4,986.1	(17,384.3)	22.3
Хүү, торгуулийн орлого	3,184.6	4,507.9	4,305.3	(202.6)	95.5
Бусад орлого	982.3	1,245.4	816.6	(428.8)	65.6
Газрын тосны орлого	8.4	-	-	-	
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	431.7	442.6	479.9	37.3	108.4
Хөрөнгө борлуулсны орлого	431.7	442.6	479.9	37.3	108.4
ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ		-	-	-	
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,420.2	53,804.5	52,435.5	(1,369.1)	97.5
ОНХН сангаас шилжүүлсэн орлого	13,941.3	17,014.6	17,014.6	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35,277.3	36,350.6	35,221.9	(1,128.7)	96.9
Бусад тусламж	201.6	439.3	198.9	(240.4)	45.3

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.10 Тайлант оны орлого нийт дүнгээр 28,155.7 сая төгрөгөөр дутуу биелсэн байна. Эдгээр орлого тасарсан шалтгаан нь Сангийн яам жил бүр өндөр дүнгээр суурь орлогыг төлөвлөснөөс шалтгаалсан байна. Тухайлбал:

Газрын төлбөр 7,140.6 сая төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр 5,095.8 сая төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 808.2 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 202.6 сая төгрөгөөр, бусад орлого 428.8 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 1,128.7 сая төгрөгөөр, бусад тусламж 240.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

1.11 Харин төсөвт байгууллагын өөрийн орлого 6,813.5 сая төгрөгөөр тасарсан нь өнгөрсөн онуудад олгосон орон сууц сангийн зээлийн авлагад төлөлт хийгээгүйтэй холбоотой байна.

1.12 Зарим нэр төрлийн орлогын гүйцэтгэл төлөвлөлтөөс 5-267 хувиар давсан нь орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай төлөвлөж байгаатай холбоотой байна. Тухайлбал:

Орлогын албан татвар 7 хувиар, Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 5 хувиар, үйл ажиллагааны орлого 161 хувиар, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар 23 хувиар, Үл хөдлөх хөрөнгийн татвар 8 хувиар, Өмчийн татвар 8 хувиар, Бууны албан татвар 11 хувиар, Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар 24 хувиар, Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 24 хувиар, Дуудлага

худалдаа сонгон шалгаруулалт 63 хувиар, Ан амьтны нөөц ашигласны төлбөр 141 хувиар, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 34 хувиар, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 60 хувиар, Түрээсийн орлого 267 хувиар, Бусад татвар хураамж 42 хувиар, Хөрөнгө борлуулсны орлого 8 хувиар тус тус давсан байна.

1.13 Жил дараалан төсвийн орлого тасарч байгаа нь орлогын төлөвлөлттэй холбоотой байгаа тул төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй тооцож байхын тулд Сангийн яам болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах зөвлөмжийг Аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.14 Тайлант онд аймгийн онцгой комисс 43 иргэн, аж ахуйн нэгжээс 908.9 сая төгрөгийн эд материал, 38.3 сая төгрөгийг бэлнээр нийт 947.2 сая төгрөгийн хандив авч Онцгой байдлын газар болон аймгийн ЗДТГ-аар дамжуулан Covid-19 өвчний эсрэг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

БҮЛЭГ 2 Төсвийн зарлагын гүйцэтгэл 89.5 хувьтай байна

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Сангийн яамнаас нийт зарлагын дүнг 44,908.4 сая төгрөгөөр хянасан бөгөөд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2020 оны 2/8 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2021 оны төсөв батлах тухай” тогтоолд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 248,901.6 сая төгрөгөөр баталсан байна.

2.2 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор 2021 оны төсвийн нийт зарлагыг 8,177.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №3 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он		
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
А	1	2	3	4=3-2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,076.2	248,901.6	257,079.1	8,177.5
УРСГАЛ ЗАРДАЛ	134,305.3	161,974.2	164,494.7	2,520.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,748.9	81,487.8	84,386.1	2,898.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,368.8	37,353.9	39,213.1	1,859.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,082.0	4,858.2	5,429.4	571.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,106.8	7,422.1	7,590.5	168.4
Хангамж, бараа материалын зардал	2,567.9	2,391.6	2,795.1	403.5
Норматив зардал	3,133.5	3,572.1	1,940.3	(1,631.8)
Эд хогшил, урсгал засварын зардал	718.4	782.5	1,338.5	556.0
Томиллолт, зочны зардал	188.6	274.2	183.7	(90.4)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,564.0	3,907.6	4,999.3	1,091.7
Бараа үйлчилгээний бусад зардал	21,018.8	20,925.7	20,896.0	(29.7)
ХҮҮ	-	-	-	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
ТАТААС	180.0	187.2	45.5	(141.7)
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	180.0	187.2	45.5	(141.7)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,376.4	80,299.1	80,063.1	(236.0)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,787.5	79,045.1	78,702.5	(342.6)
Бусад урсгал шилжүүлэг	1,588.8	1,254.1	1,360.6	106.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,770.9	86,927.4	92,584.4	5,657.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,076.2	248,901.6	257,079.1	8,177.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,457.8	52,466.3	53,365.2	898.9
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	35,269.3	35,734.2	36,350.6	616.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,188.5	16,732.1	17,014.6	282.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,546.7	187,103.5	183,543.2	(3,560.2)
Орон нутгийн төсвөөс	172,546.7	187,103.5	183,543.2	(3,560.2)
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-	-	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,820.6	9,331.8	9,338.0	6.2
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	251.1	439.3	439.3	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	3,900.4	10,832.6	6,932.2

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.3 Төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлэн баталсан нь цар тахлын цар хүрээ багасаж уул уурхайн үйл ажиллагаа жигдэрч орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.4 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор 2021 оны төсвийн нийт зарлагыг 257,079.1 сая төгрөгөөр баталж 230,081.8 сая төгрөг буюу 89.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.5 Орон нутгийн нэгтгэсэн төсвийн зарлагын дүнд урсгал зардал 67.5 хувь, хөрөнгийн зардал 32.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт №4 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү +/-
А	1	2	3	4=3-2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,686.4	257,079.1	230,081.8	(26,997.3)
УРСГАЛ ЗАРДАЛ	111,516.4	164,494.7	155,306.9	(9,187.8)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,681.6	84,386.1	75,444.3	(8,941.8)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,898.7	39,213.1	37,914.4	(1,298.7)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,735.8	5,429.4	5,086.8	(342.6)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,669.3	7,590.5	6,331.4	(1,259.1)
Хангамж, бараа материалын зардал	2,345.4	2,795.1	2,603.4	(191.7)
Норматив зардал	1,997.0	1,940.3	1,554.8	(385.5)
Эд хогшил, урсгал засварын зардал	454.9	1,338.5	1,233.8	(104.7)
Томилолт, зочны зардал	95.0	183.7	141.9	(41.8)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,566.4	4,999.3	4,038.4	(960.9)
Бараа үйлчилгээний бусад зардал	18,919.1	20,896.0	16,539.2	(4,356.8)
ТАТААС	145.9	45.5	45.5	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	145.9	45.5	45.5	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,688.9	80,063.1	79,817.1	(246.0)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	36,353.5	78,702.5	78,701.9	(0.6)

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Бусад урсгал шилжүүлэг	1,335.3	1,360.6	1,115.3	(245.4)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,170.1	92,584.4	74,774.9	(17,809.5)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	204,376.2	257,079.1	228,923.4	(28,155.7)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,799.5	53,365.2	52,236.6	(1,128.6)
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	32,858.2	36,350.6	35,221.9	(1,128.7)
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	13,941.3	17,014.6	17,014.6	0.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	155,314.9	183,543.2	173,963.4	(9,579.8)
Орон нутгийн төсвөөс	155,314.9	183,543.2	173,963.4	(9,579.8)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,060.2	9,338.0	2,524.5	(6,813.5)
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	201.6	439.3	198.9	(240.4)
БУСАД ЭХ ҮҮСВЭР /шилжих үлдэгдэл/	-	10,393.3	-	(10,393.3)

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.6 Төсвийг хэмнэсэн гол шалтгаан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол гарч төсвийн хэмнэлтийн горимд шилжин, төсөвт зохицуулалт хийж эдийн засгийн ангилал бүрээр хэмнэлттэй ажилласан байна.

2.7 Өмнөговь аймгийн хэмжээнд 124 байгууллага 26,744.0 сая төгрөгийн өртөг бүхий 685 автомашин ашиглаж байгаа ба 2021 онд автомашинтай холбоотойгоор төсвөөс дунджаар 4,029.6 сая төгрөгийн урсгал зардал гарсан байна.

2.8 Улс орон даяар эдийн засгийн хүнд нөхцөл байдал үүсэж байгаа тул төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудад хэмнэлт гаргах автомашинтай холбоотой асуудлыг зөвлөмжөөр хүргүүлэв.

Хүснэгт №5 Төсвийн тэнцэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	178,355.8	257,079.1	228,923.4	(28,155.7)
УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	128,504.0	189,799.5	171,021.9	(18,777.6)
Татварын орлого	111,726.8	138,846.2	137,595.7	(1,250.5)
Татварын бус орлого	16,777.2	50,953.3	33,426.2	(17,527.1)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	431.6	442.6	479.9	37.3
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,420.2	66,837.0	57,421.6	(9,415.4)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,686.4	257,079.1	230,081.8	(26,997.3)
УРСГАЛ ЗАРЛАГА	111,516.3	164,494.7	155,306.9	(9,187.8)
Бараа, үйлчилгээний зардал	73,681.6	84,386.1	75,444.3	(8,941.8)
Цалин, хөлс	34,898.7	39,213.1	37,914.4	(1,298.7)
Нийгмийн даатгалын шимтгэл	4,735.8	5,429.4	5,086.8	(342.6)
Бараа, үйлчилгээний бусад зардал	34,047.1	39,743.6	32,443.0	(7,300.6)
Татаас ба урсгал шилжүүлэг	37,834.7	80,108.6	79,862.6	(246.0)
Татаас	145.9	45.5	45.5	-
Урсгал шилжүүлэг	37,688.8	80,063.1	79,817.1	(246.0)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,170.1	92,584.35	74,774.86	(17,809.5)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
УРСГАЛ ТЭНЦЭЛ	16,987.7	25,304.8	15,715.0	(9,589.8)
НИЙТ ТЭНЦЭЛ	(22,330.6)	-	-	1,158.4

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР	(22,330.6)	-	-	1,158.4	(1,158.4)
Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	(22,330.6)	-	-	1,158.4	(1,158.4)
Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	-	0	-	-	-
Бусад	-	0	-	-	-

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Тайлант онд цар тахлын нөхцөл байдал сайжирч уул уурхай сэргэсэн нь өмнөх оны орлогын гүйцэтгэлээс энэ оны орлогын гүйцэтгэл 29,394.6 сая төгрөгөөр өсөх шалтгаан болсон байна.

2.10 Өмнөх онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 15,434.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж байсан бол энэ онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 78,349.7 сая төгрөгөөр төлөвлөж 100 хувь биелүүлэн төвлөрүүлсэн байна.

ТАТВАРЫН ЗАРЛАГА

2.11 Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/340 дугаар захирамжаар 2020 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 1021 иргэнд 947.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.12 Өмнөговь аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн нийт 26,811.7 сая төгрөгийн татварын өр төлбөр байна. Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.8⁴-д заасантай нийцэхгүй байгаа тул төсвийн ерөнхийлөн захирагчид татварын өр төлбөрийг барагдуулах талаар ажил зохион байгуулах зөвлөмж хүргүүлэв.

Хүснэгт №6 Татварын өр төлбөр сумдаар

/сая төгрөг/

№	Сумдын нэр	Иргэн, ААН	Татварын өр төлбөр
1	Баяндалай	ААН	63.1
		Иргэн	13.0
2	Баян-Овоо	ААН	14.8
		Иргэн	15.5
3	Булган	ААН	8.0
		Иргэн	9.7
4	Гурвантэс	ААН	5,297.9
		Иргэн	22.8
5	Манлай	ААН	2.9
		Иргэн	8.3
6	Мандал-Овоо	ААН	7.9
		Иргэн	9.3
7	Ноён	ААН	63.0
		Иргэн	10.7
8	Номгон	ААН	6.8
		Иргэн	13.7
9	Даланзадгад	ААН	18,740.2
		Иргэн	153.3
10	Ханхонгор	ААН	19.5
		Иргэн	10.6
11	Ханбогд	ААН	1,557.5
		Иргэн	57.1
12	Хүрмэн	ААН	7.2
		Иргэн	4.7
13	Сэврэй	ААН	0.1
		Иргэн	15.9

⁴ “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”

14	Цогтцэций	ААН	597.9
		Иргэн	71.6
15	Цогт-Овоо	ААН	1.9
		Иргэн	6.7
НИЙТ ДҮН			26,811.7

Эх сурвалж: Татварын хэлтэс

БҮЛЭГ 3 Тайлант онд 95,975.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2⁵-т заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр баригдах болон засварлах барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалт, төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт №7 Худалдан авах ажиллагааны товчоо

Д/Д	Захиалагч байгууллагын нэр	Нийт төсөл арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг (сая төгрөг)
1	Орон нутгийн өмчийн газар	175	77,926.8
2	Баяндалай сумын Засаг даргын Тамгын газар	4	248.5
3	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	6	733.7
4	Булган сумын Засаг даргын Тамгын газар	2	78.9
5	Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газар	8	1,066.9
6	Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар	14	824.6
7	Мандал-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	4	210.0
8	Манлай сумын Засаг даргын Тамгын газар	8	563.5
9	Ноён сумын Засаг даргын Тамгын газар	10	2,432.6
10	Номгон сумын Засаг даргын Тамгын газар	3	330.2
11	Сэврэй сумын Засаг даргын Тамгын газар	3	2,174.0
12	Ханбогд сумын Засаг даргын Тамгын газар	17	3,705.2
13	Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газар	5	506.4
14	Хүрмэн сумын Засаг даргын Тамгын газар	2	75.0
15	Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	8	761.4
16	Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газар	14	1,376.7
17	Хөгжил хөрөнгө оруулалтын газар	7	886.0
18	Таван толгой ХК	16	2,074.9
	Нийт	306	95,975.5

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

3.2 Тайлант онд нийт 95,975.5 сая төгрөгийн 306 худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас 57.1 хувь буюу 175 худалдан авах ажиллагааг орон нутгийн өмчийн газар зохион байгуулсан байна.

3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчид тайлант оны худалдан авсан бараа, ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5⁶ дахь хэсэгт зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнасан байна.

⁵ “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн гаргаж, төсвийн төслийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”

⁶ “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид ...”

Хүснэгт№8 Худалдан авах ажиллагааны товчоо


/сая төгрөг/

Д/Д	Эх үүсвэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Нээлттэй тендер шалгаруулалтын	Хязгаарлагдмал тендер	Харьцуулалтын арга	Цахим тендер шалгаруулалтын тоо	Шууд гэрээ байгуулах арга	Шууд худалдан авалт	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах журам	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны	Нийт
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	1,305.0	5		2						7
2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	65,880.5	75		38				13		126
3	Орон нутгийн хөгжлийн сан	4,853.6	10		2				17		29
4	Говийн оюу хөгжлийг дэмжих сан	5,384.7	5		1				4		10
5	Бусад	18,551.7	53		69				12		134
	Нийт	95,975.5	148		112				46		306

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газар

3.4 Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 148, харьцуулалтын аргаар 112, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах журмын дагуу 46 бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

График №1 Худалдан авах ажиллагааны эх үүсвэрийн ангилал



3.5 Нийт худалдан авах ажиллагааны 41 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 44 хувийг сумдын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн өмчит аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр, 10 хувийг аймгийн орон нутгийн хөгжлийн сан, 3 хувийг говийн оюу хөгжлийг дэмжих сан, 2 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн байна.

БҮЛЭГ 4 Хөтөлбөрүүдэд 10,468.1 сая төгрөг зарцуулсан байна.

4.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн Хишиг" мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №9 Төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

№	Эх үүсвэр	Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	2021 онд олгох санхүүжилтийн дүн	2021 онд олгосон санхүүжилтийн дүн	Гүйцэтгэлийн хувь
1	ОНХС	11	12,973.4	12,348.3	11,686.7	11,405.7	97.6
2	ОНТХО	91	50,085.4	73,761.6	45,627.8	40,884.4	89.6
3	БХ-ХО	17	6,944.0	8,789.1	6,496.2	6,057.7	93.2
4	Замын сан	2	5,989.5	11,867.8	5,957.1	5,957.1	100
5	Хөтөлбөр	47	12,619.3	12,619.3	12,619.3	10,468.1	82.9
	Дүн	168	88,611.6	119,386.1	82,387.1	74,773.0	90.7

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

4.2 Нийт төсөл арга хэмжээнд тайлант онд 82,387.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 74,773.0 сая төгрөгийг зарцуулж 90.7 хувийн төсвийн гүйцэтгэлтэй байна.

4.3 ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн 11 төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60.3⁷-т заасан хориглох зүйлд зарцуулаагүй, төсөл арга хэмжээнүүд иргэдийн саналаар дэмжигдсэн байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

4.4 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2020 оны 2/8 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхээр 48 дэд хөтөлбөрийн жагсаалтыг баталсан байна.

4.5 Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 3/2 дугаар тогтоолоор Орон нутагтаа тогтвор суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг гадаад дотоодод туршлага судлуулах, мэргэшүүлэх “Хөгжлийн гүүр” хөтөлбөр, аймгийн 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулж, үндэсний ёс заншил уламжлалаа дэмжин хөгжүүлэх гэсэн 2 хөтөлбөрийг цар тахлаас шалтгаалан хасаж, “Говь+Ус” хөтөлбөрийн хүрээнд саарал ус ашиглалтын өнөөгийн байдлын судалгааг аймгийн хэмжээнд хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого арга хэмжээг тодорхойлох 1 хөтөлбөрийг нэмж нийт 47 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тодотгон баталсан байна.

Хүснэгт №10 Дэд хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв

/сая төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
1	Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах зорилгоор “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	62.5	38.7	61.9
2	Элэгний хатуурал, хорт хавдраас сэргийлэх “Эрүүл элэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	67.6	58.0	85.8
3	Амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	98.9	49.7	50.2
4	Эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх “Сүү тараг” хөтөлбөр, “Харшлын эсрэг тэмцье” хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулах, судалгаа, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулж хэрэгжүүлэх	200.0	95.0	47.5

⁷ “ОНХС-ын хөрөнгийг дараах зүйл зарцуулахыг хориглоно”

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

5	Иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, дасгал хөдөлгөөн, иог, бүжиг, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх үйл ажиллагааг дэмжих	50.0	37.0	73.9
6	Эмч мэргэжилтний мэдлэг ур, чадвар, ёс зүй хариуцлага, харилцаа хандлагыг сайжруулах сургалт, арга хэмжээ зохион байгуулах	10.0	10.0	99.8
7	Аймгийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөх "Өмнөговийн иргэдэд зөвлөн зуучлах төв"-ийг Улаанбаатар хотод байгуулах	12.0	-	-
8	Хүүхдэд Монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч,эрх чөлөөт сэтгэлгээтэй, үндэсний бахархлыг төлөвшүүлж, "Говийн ирээдүй-Хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	180.0	168.3	93.5
9	Багш өөрөө хөгжих "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Багшийн хөгжлийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	400.0	364.8	91.2
10	Салбар бүрийн мэргэжилтнүүдийг аймаг орон нутагтаа ирж ажиллахыг дэмжих "Өмнөговьдоо ажиллаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	75.0	28.5	38.0
11	Хүүхэд залуус, иргэдийн цахим боловсролыг дэмжих "Цахим Өмнөговь", "Сурагч солилцоо" хөтөлбөрийг боловсруулж эхлүүлэх	50.0	29.6	59.1
12	"Хос сайхан бичигтэн- Өмнөговь" уламжлалыг сэргээж, монгол хэл бичгээрээ зөв сайхан бичих чадварыг бий болгох	7.0	5.1	72.4
13	Тусгай хэрэгцээт боловсролын анги бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, тусгай багш, мэргэжилтэн бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх	10.0	8.7	86.9
14	Дутагдалтай боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, оюутны тэтгэлгийг олгох, их сургууль аж ахуйн нэгжтэй хамтарсан нэгдмэл тэтгэлгийн сан байгуулах	425.0	387.7	91.2
15	Уул уурхайн инженер, мэдээллийн технологи, төмөр замын их дээд сургууль буюу салбар байгуулах, Политехникийн коллежид шинэ анги нээх ажлыг эхлүүлэх	50.0	21.5	43.1
16	Математикийн сургалтын чанарыг сайжруулах, арга зүй, туршлага солилцох зорилгоор улсын математикийн олимпиадыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	110.0	42.2	38.4
17	Өмнөговь аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд зориулан аймгийн түүх соёлын ном, уран бүтээл, оюуны бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	224.0	204.7	91.4
18	Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх	300.0	300.0	100.0
19	Залуучуудын эрүүл мэнд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжихэд чиглэсэн "Залуус" хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	380.0	341.0	89.7
20	Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах	300.0	265.6	88.5
21	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах зорилгоор "Өсөлтийг өрх бүрт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,000.0	618.5	61.9
22	Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлт, хөгжил хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	245.0	191.6	78.2
23	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах	25.0	17.5	70.0
24	Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, Монгол гэрийн халаалт дулаалгын багцыг нэвтрүүлэх	300.0	296.7	98.9
25	Нийтийн ахуй үйлчилгээ эрхлэгчдийн холбоод, хамтын ажиллагааг дэмжиж ажиллах	30.0	15.0	50.0
26	Малчдын орлогыг улирлын нөлөөнөөс хамаарал багатай байлгах зорилготой "Чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлэх	466.0	333.3	71.5
27	Тэмээний ашиг шимт бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжих	30.0	-	-
28	Тариалалт, ургацыг нэмэгдүүлж, хадгалж нөөцлөх боломжийг бүрдүүлэн, орон нутгийн хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилгоор орон нутгийн өмчит энгийн зоорийг засварлах /Сэврэй, Хүрмэн, Ханбогд, Ноён/,	60.0	38.1	63.6
29	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, хүнсний ногоог борлуулах "Өмнөговьд үйлдвэрлэв", "Өмнөговьд тарьж ургуулав"	30.0	30.0	100.0

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	борлуулалтын цэгийг Өмнөговь, Улаанбаатар хотод бий болгож, баялаг бүтээгчид, малчдыг дэмжих			
30	Малчдын хоршоог чадавхжуулах, хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн тасаг, мэргэжлийн үйлчилгээний нэгжүүдийн мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт, эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажил хийх, сайн туршлага нэвтрүүлэх	46.3	29.8	64.4
31	Даланзадгад сумын хүн амын хавар зуны улирлын хэрэгцээг хангах зорилгоор махны нөөц бүрдүүлэх	200.0	160.0	80.0
32	Малын төрөл хоорондын харьцааг зохистой түвшинд хүргэж, түргэн өсөлттэй хонины аж ахуй, мал бордох цэгийг хөгжүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх	401.0	181.8	45.3
33	Иргэдийг урьдчилан сэргийлэх, үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулж, эрүүлжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах	179.0	48.5	27.1
34	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрыг шийдвэрлэх зорилгоор ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах	30.0	-	-
35	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор "Шинэ мянган айл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх /Булган/	740.0	702.3	94.9
36	Төр, хувийн хэвшлийн оролцоотой "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх /Мандал-Овоо, Хүрмэн/	700.0	683.1	97.6
37	"Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийн хүрээнд хүрээнд сумдад орон сууцны барилгыг барьж дуусгах	1,975.0	1,864.5	94.4
38	Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, төрийн албан харилцааны соёл, хандлагыг шинэ шатанд гаргах "Танд үйлчилье" аяныг өрнүүлж, иргэдийн итгэл хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэх хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах нэгдсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулах	50.0	30.2	60.4
39	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	800.0	796.3	99.5
40	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, сум, баг, хилийн боомтод төрийн үйлчилгээг нэг цэгээс шуурхай хүргэх "Явуулын оффис" ажиллуулах	100.0	-	-
41	Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд "Нутгийн дэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,650.0	1,438.4	87.2
42	Төр хувийн хэвшлийн байгууллагуудад олон улсын стандартуудыг нэвтрүүлж, үйлчилгээний чанар хүртээмж, бүтээмжийг нэмэгдүүлэх	80.0	69.6	87.0
43	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутагт шударга өрсөлдөөнийг зохицуулах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, өмгөөлөгчтэй хамтран ажиллах	40.0	39.9	99.8
44	Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архинаас татгалзсан иргэдийг ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх	20.0	18.7	93.6
45	Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Ээлтэй Өмнөговь" хөтөлбөр хэрэгжүүлэх	70.0	68.5	97.8
46	"Пибоди винсвэй ресорсез" ХХК-ийн нөхөн төлбөрийг төлөх	300.0	300.0	100.0
47	"Говь+Ус" хөтөлбөрийн хүрээнд саарал ус ашиглалтын өнөөгийн байдлын судалгааг аймгийн хэмжээнд хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого арга хэмжээг тодорхойлох	40.0	40.0	100.0
	Нийт дүн	12,619.3	10,468.1	82.9

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

4.6 Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 10,468.1 сая төгрөг буюу 82.9 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна.

4.7 Цар тахалтай холбоотойгоор зарим хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт удааширсан нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

4.8 Тайлант онд төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлээгүй байна. Зарим хөтөлбөрийн хүрэх түвшин хэт ерөнхий, хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан, төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, үр дүнгийн танилцуулгыг бэлтгээгүй байна.

БҮЛЭГ 5 Нэмэлт төсвийг холбогдох журмын дагуу зарцуулсан байна.


5.1 Төсвийн шууд захирагчид нэмэлт төсвийг Төсвийн тухай хуулийн 47⁸ дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгүүлэн ажилласан байна.

5.2 Нэмэлт төсвийг төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 86.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,367.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,958.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,929.3 сая, нийт 16,340.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

5.3 Нэмэлт төсвийг зарцуулахдаа цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 538.6 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 41.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 350.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 53.2 сая төгрөг, норматив зардалд 1,246.0 сая төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардал 532.9 сая төгрөг, томилолтын зардал 67.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 554.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,188.4 сая төгрөг, тэтгэмж шагнал урамшууллын зардалд 1,681.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 854.3 сая төгрөгийг зарцуулж, улс, орон нутгийн төсөвт 203.9 сая төгрөгийг төвлөрүүлж, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 28.1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

5.4 Нэмэлт орлогоос Төсвийн тухай хуулийн 46.5.1⁹-д заасан хориглох арга хэмжээнд зарцуулсан зарцуулалт байхгүй байна.

График №2 Нэмэлт төсвийн зардлын ангилал



⁸ “Нэмэлт төсөв”

⁹ “Байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах дараахь тохиолдолд”

Хүснэгт №11 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Сумдын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он		
			Санхүүжилт	Зарцуулалт	Үлдэгдэл
1	Баяндалай	1,360.8	981.3	981.3	-
2	Баян-Овоо	1,213.5	191.3	191.3	-
3	Булган	1,037.0	368.4	367.0	1.5
4	Гурвантэс	1,755.2	1,817.7	1,817.7	-
5	Мандал-Овоо	1,937.8	2,034.4	2,034.4	-
6	Манлай	1,798.8	642.6	637.3	5.3
7	Номгон	925.8	243.4	238.2	5.3
8	Ноён	492.7	272.9	272.9	-
9	Сэврэй	1,385.6	2,045.7	2,045.7	0.1
10	Ханбогд	1,616.9	1,211.2	1,205.5	5.7
11	Ханхонгор	427.9	526.7	526.0	0.7
12	Хүрмэн	221.1	165.2	165.2	-
13	Цогт-Овоо	1,304.2	1,326.7	1,319.9	6.8
14	Цогтцэций	1,032.8	795.2	792.4	2.8
15	Даланзадгад	8,615.6	1,005.3	1,005.3	-
16	Аймгийн төвийн төсвийн байгууллагууд	3,463.8	2,712.3	2,712.3	-
	Дүн	28,589.5	16,340.5	16,312.4	28.1

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

5.5 Нэмэлт санхүүжилтийн 83.2 хувь буюу 13,572.6 сая төгрөг нь бараа үйлчилгээний зардал, 11.6 хувь буюу 1,885.5 сая төгрөг нь урсгал шилжүүлэг, 5.2 хувь буюу 854.3 сая төгрөг нь хөрөнгийн зардал байна.

5.6 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 12,277.1 сая төгрөгөөр буюу 57.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь орон нутгийн хөрөнгөөр эрх шилжин хийгдсэн хөрөнгө оруулалтуудын тоо буурсан нь нөлөөлжээ.

Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн байна
- Төсвийн орлогын төлөвлөгөө 28,155.7 сая төгрөгөөр тасарсан байна
- Төсвийн зарлагын гүйцэтгэл 89.5 хувьтай байна
- Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн нийт 26,811.7 сая төгрөгийн татварын өр төлбөр байна
- Тайлант онд автомашинтай холбоотойгоор төсвөөс дунджаар 4,029.6 сая төгрөгийн урсгал зардал гарсан байна
- Тайлант онд 95,975.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна
- Хөтөлбөрүүдэд 10,468.1 сая төгрөг зарцуулсан байна
- Нэмэлт төсвийг холбогдох журмын дагуу зарцуулсан байна

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржид:

1. Жил дараалан төсвийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа нь төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотой байгааг харуулж байна. Иймд төсвийн төлөвлөлтийг Сангийн яам болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллаж үндэслэлтэй төлөвлөх,

2. Өмнөговь аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн 26,811.7 сая төгрөгийн татварын өр төлбөр байна. Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасантай нийцэхгүй байгаа тул татварын өр төлбөрийг барагдуулах талаар ажил зохион байгуулах.

3. Автомашин ашиглах эрх бүхий албан байгууллага, албан тушаалтнуудыг баталж төсвийн зарлагыг хэмнэх, төрийн байгууллагын авто машинуудад таних тэмдэг, хаягжуулалд хийж иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх.

Зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дарга, Тэргүүлэх аудиторын тушаал



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/8

Даланзадгад

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-д үүрэг болгосугай.


С.ЦЭРЭНБАЯР

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2022\А-08.Docx

016310007